



BRINK'S
ОЛОН УЛСЫН ӨГӨГДӨЛ
ХАМГААЛАЛТЫН БОДЛОГО

АГУУЛГЫНХҮСНЭГТ

A. ЗОРИЛГО.....	3
B. ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
C. ДАГАЖ МӨРДӨХ.....	4
D. НЭР ТОМЬЁО/ҮҮРЭГ & ТОДОРХОЙЛОЛТ.....	5
E. ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАН.....	6
F. ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛТЫН ЗАРЧИМ	
F.1 ХУУЛЬ ЁСТ БАЙДАЛ, ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДАЛ.....	7
F.2 ЗОРИЛГЫН ХЯЗГААРЛАЛТ.....	8
F.3 ӨГӨГДЛИЙН БАГАСГАЛТ.....	8
F.4 ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ.....	8
F.5 ХАДГАЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ.....	8
F.6 ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ НЬ.....	9
F.7 ДАМЖУУЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ.....	10
F.8 ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ.....	10
F.9 ӨГӨГДЛИЙН СУБЪЕКТҮҮДИЙН ЭРХ БА ХҮСЭЛТҮҮД.....	11
G. ХАРИУЦЛАГА	12
H. ЖИЛИЙН ТОЙМ.....	12

A. ЗОРИЛГО

Brink's-н Ёс зүйн дүрэмд заасны дагуу Brink's компани, түүний охин ба түншлэгч компаниуд нь үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, ажилчид, албан хаагчид болон бусад гуравдагч этгээдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй.

Энэхүү Бодлого нь Brink's-н бүх нэгжүүд Хувийн мэдээллийн боловсруулалтыг зохицуулдаг өгөгдөл хамгаалалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон болно ("Зарчим").

Энэхүү Бодлого нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Brink's-н үйл ажиллагааны явцад Боловсруулсан хувийн мэдээллийг хамгаалахад зориулагдсан Brink's-н өгөгдлийн хамгаалалтад төвлөрсөн соёл, дадлын хүрээнд сурталчлах зорилготой юм.

* Энэхүү Бодлогод ашигласан том үсгээр бичсэн нэр томъёо эсвэл товчилсон үгийн утгыг "Нэр томъёо/Үүрэг ба Тодорхойлолт" хуудсанд заасан болно.



В. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү Бодлого нь Brink's-н бүхийл үйл ажиллагааны чиглэл болон Brink's-н нэгжүүдийн тус тусын шийдвэр гаргах дүрмийн хүрээнд үйлчилнэ. Энэ нь өгөгдлийн хадгалагдаж буй сувгаас үл хамааран Brink's-н Боловсруулсан бүх хувийн мэдээллийг хамарах бөгөөд ирээдүйн, өнгөрсөн эсвэл одоогийн ажилтан, албан хаагчид, хэрэглэгчид, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, хувьцаа эзэмшигчид, вебсайтын хэрэглэгчид болон бусад хувь хүнтэй холбоотой байж болно.

Энэхүү Бодлогыг олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилготой боловч Brink's үйл ажиллагаагаа явуулж буй улс орнуудын өгөгдөл хамгаалах хууль, дүрэмийн хүрээнд үйлчилнэ. Зарим улсад энэхүү Бодлогод тусгаснаас гадна нэмэлт үүрэг хариуцлага эсвэл зарчмуудыг хүлээлгэх өгөгдөл хамгаалах хууль тогтоомж, дүрэм журам байж болно. Эдгээр нэмэлт шаардлагыг дагаж мөрдөхийн тулд Brink's нь энэхүү Бодлогод ("Дэд бодлого"), тухайлбал Европын эдийн засгийн бүс болон Нэгдсэн Вант Улсад хэрэгждэг Бодлого буюу Тухайн бүс нутгийн хууль тогтоомжид тохирсон хувилбарыг бий болгож болно.

Эдгээр Дэд бодлогыг Brink's-н холбогдох дотоод сүлжээнд байршуулах эсвэл дотоодын DPO, Хуулийн эсвэл Хүний нөөцийн төлөөлөгчийн хүсэлтээр ил гаргаж болно. Эдгээр Дэд бодлого нь Бодлогын хавсралт болж өгөх зорилготой юм. Энэхүү Бодлого болон ийм Дэд бодлогын хооронд зөрчил гарсан тохиолдолд Дэд бодлогод хамаарах бүс нутаг дахь Brink's-н үйл ажиллагаа эсвэл Боловсруулалтын үйл ажиллагааг Дэд бодлогын дагуу зохион байгуулна.

С. ДАГАЖ МӨРДӨХ

Brink's-н бүх бие бүрэлдэхүүн Brink's-н нэрийн өмнөөс Хувийн мэдээллийг боловсруулахдаа энэхүү Бодлогыг уншиж, ойлгон, дагаж мөрдөх ёстой. Энэхүү бодлого болон Хэрэгжүүлэх бүх баримт бичгийг заавал дагаж мөрдөх шаардлагатай. Энэхүү Бодлогыг ямар нэгэн байдлаар зөрчих тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүнд сахилгын арга хэмжээ болон Brink's-г их хэмжээний санхүүгийн торгууль ногдуулж болзошгүй.



D.

НЭР ТОМЬЁО/ҮҮРЭГ & ТОДОРХОЙЛОЛТ

Brink's-н аж ахуйн нэгж: Brink's-н компани болон түүний охин компаниуд.

Brink's-н бие бүрэлдэхүүн: Brink's-н бүх албан хаагчид, гэрээлэгчид, захирлууд, гишүүд.

Өгөгдөл хамгаалалтын ажилтан (DPO): Brink's-н өгөгдөл хамгаалалтын биелүүлэлтийг хянах үүрэг хүлээсэн, албан ёсоор томилогдсон хүн эсвэл баг.

Өгөгдлийн субъект: Хувийн мэдээлэл нь боловсруулгдаж буй хэн болохыг нь тодорхой эсвэл тодорхойлох боломжтой хувь хүн. Өгөгдлийн субъект нь аль ч улсын иргэн, оршин суугч байж болох бөгөөд тэд Хувийн мэдээлэлтэйгээ холбоотой хууль ёсны эрхтэй байна.

Хэрэгжүүлэх баримт бичиг: Энэхүү Бодлоготой холбоотой мөн Хувийн мэдээллийг хамгаалах зорилготой Brink's-н бодлого, үйл ажиллагааны журам, үйл явц эсвэл удирдамж.

Хувийн мэдээлэл: (1) тодорхойлсон эсвэл тодорхойлох боломжтой хувь хүнтэй холбоотой эсвэл (2) тодорхой хувь хүн эсвэл өрхтэй шууд болон шууд бус байдлаар тодорхойлох, холбогдох, дүрслэх, холбогдож болох, холбоотой байх боломжтой аливаа мэдээлэл. Үүнд бид тухайн өгөгдлөөс дангаараа эсвэл бидний эзэмшиж байгаа эсвэл хандах боломжтой өөр бусад таних тэмдгүүдтэй хослуулан (шууд эсвэл шууд бусаар) тодорхойлох боломжтой хувь хүнтэй холбоотой мэдээллийг багтаасан болно, тухайлбал нэр, таних дугаар, байршлын мэдээлэл, онлайн танигч эсвэл тухайн Өгөгдлийн субъектийн бие махбод, физиологи, генетик, сэтгэц, эдийн засаг, соёлын болон нийгмийн онцлогтой холбоотой нэг эсвэл хэд хэдэн хүчин зүйл гэх мэт тодорхойлогч. Хувийн мэдээлэлд тодорхой нэргүй өгөгдөл эсвэл хувь хүнийг тодорхойлох мэдээллийг устгасан өгөгдөл орохгүй.

Хувийн мэдээллийн зөрчил: Brink's эсвэл түүний үйлчилгээ үзүүлэгчдийн дамжуулсан, хадгалсан эсвэл өөр аргаар Боловсруулсан Хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй эсвэл санамсаргүй байдлаар хандах, хаягдуулах, ашиглах, өөрчлөх, устгах, олж авах, задруулах аливаа бодит эсвэл үндэслэлтэй сэжигтэй үйлдэл.

Нууцлалын мэдэгдэл (өөрөөр Шударга боловсруулалтын мэдэгдэл гэнэ) эсвэл Нууцлалын бодлого: Brink's тэдний тухай Хувийн мэдээллийг цуглуулах үед Өгөгдлийн субъектүүдэд өгч болох мэдээллийг тусгасан тусдаа мэдэгдэл.

Боловсруулалт эсвэл боловсруулах: цуглуулах, бүртгэх, нэгтгэх, хадгалах, тааруулах, өөрчлөх, сэргээх, лавлах, ашиглах, дамжуулах замаар илчлэх эсвэл гуравдагч этгээдэд түгээх, ил болгох эсвэл бусад хэлбэрээр ашиглах, тохируулах эсвэл хослуулах, хязгаарлах, устгах, арилгах гэх мэт автомат хэрэгслээр хийсэн эсэхээс үл хамааран Хувийн мэдээлэл эсвэл Хувийн мэдээллийн хувилбарууд дээр гүйцэтгэдэг аливаа үйлдэл эсвэл бүлэг үйл ажиллагаа.

Нууц нэр эсвэл нууц нэртэй болгох: хувь хүнийг шууд болон шууд бусаар таних нэг эсвэл хэд хэдэн зохиомол таних тэмдэг эсвэл нууц нэрээр орлуулах ба ингэснээр өгөгдлийн хамааралтай этгээдийг тусад нь байлгаж, аюулгүй байлгах зорилгоор нэмэлт мэдээллийг ашиглахгүйгээр тодорхойлох боломжгүй болно.

Дамжуулалт: Хувийн мэдээллийг өгөгдөл хүлээн авсан гуравдагч этгээд Боловсруулахаар зориулагдсан хэмжээнд сүлжээ эсвэл бусад дамжуулагч хэрэгслийг ашиглан Хувийн мэдээлэл дамжуулах, хуулбарлах, шилжүүлэхийг дэмждэг аливаа үйлдэл эсвэл бүлэг үйл ажиллагаа. Хувийн мэдээлэлд алсаас хандах нь Дамжуулалтын жишээ юм.

Е. ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАН

Шаардлагатай тохиолдолд Brink's өгөгдөл хамгаалалтын ажилтан (DPO) томилдог.

Энэхүү Бодлогын талаар ямар нэг асуулт байвал эсвэл энэхүү Бодлогыг дагаж мөрдөхгүй байх эсвэл дагаж мөрдөөгүй талаар мэдээлэхийн тулд Brink's-н DPO эсвэл Brink's-н Хуулийн хэлтэст хандана уу. Ялангуяа дараах тохиолдолуудад DPO эсвэл Brink's-н Хуулийн хэлтэстэй холбогдох нь тохиромжтой:

- Хэрэв та Хувийн мэдээллийг холбогдох хуулийн дагуу боловсруулж байгаа эсэхэд эргэлзэж байгаа бол;
- хэрэв холбогдох хуулийн дагуу Хувийн мэдээллийг хууль ёсоор Боловсруулахад Өгөгдлийн субъектийн зөвшөөрлийг авахад танд тусламж хэрэгтэй бол;
- Хэрэв та Нууцлалын мэдэгдлийг боловсруулах хэрэгтэй бол;
- Хэрэв та Хувийн мэдээллийг хэр удаан хадгалах тухай мэдэхгүй байгаа бол;
- Хэрэв та Хувийн мэдээллийг хамгаалахад аюулгүй байдлын ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэхээ мэдэхгүй байгаа бол;
- Хэрэв Хувийн мэдээллийн зөрчил гарсан бол;
- Хэрэв та Хувийн мэдээллийг цуглуулсан улсаас өөр улс руу Хувийн мэдээллийг дамжуулахдаа ямар зарчим ашиглахаа мэдэхгүй байгаа бол;
- Хэрэв танд Өгөгдлийн субъектийн зүгээс хүссэн аливаа эрхийн талаар тусламж хэрэгтэй байгаа бол;
- Хувь хүнд ихээхэн нөлөөлөх магадлалтай, одоо хэрэгжиж буй үйл ажиллагаанд өөрчлөлт орох эсвэл шинэ үйл ажиллагаанд Хувийн мэдээллийг цуглуулахаас өөр зорилгоор үүнийг ашиглахаар төлөвлөж байгаа бол;
- Хэрэв шууд маркетингийн үйл ажиллагаа явуулахад нууцлалын тухай холбогдох хуулийг дагаж мөрдөхөд танд тусламж хэрэгтэй байгаа бол; эсвэл
- Хэрэв та Хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахтай холбоотой гэрээ эсвэл бусад чиглэлээр тусламж авах хэрэгтэй байгаа бол.



Ү. ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛТЫН ЗАРЧИМ


Brink's компани нь Brink's-н бүх аж ахуйн нэгжийг өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд Хувийн мэдээллийг боловсруулахдаа холбогдох өгөгдөл хамгаалалт ба нууцлалын хуулийг дагаж мөрдөхийг шаарддаг.

Ерөнхийдөө Brink's доор дурдсан Хувийн мэдээллийг хамгаалах зарчмуудыг дагаж мөрддөг. Эдгээр зарчим нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн гэрээнд тусгагдсан нууцлалын стандартыг агуулсан бөгөөд Brink's-н бизнесийн үйл ажиллагаа явуулдаг улс орны хууль тогтоомжуудад тусгагдсан байдаг. Эдгээр зарчимууд нь Brink's-н аж ахуйн нэгж болон тэдний бие бүрэлдэхүүний Хувийн өгөгдлийг боловсруулах бүхийл үйл ажиллагаанд хамаарна.

Ү.1. ХУУЛЬ ЁСТ БАЙДАЛ, ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДАЛ

Хувийн мэдээллийг хууль ёсны дагуу, шударга, ил тод байдлаар цуглуулж, боловсруулах ёстой.

Хувийн мэдээллийг бууль бус замаар эсвэл Өгөгдлийн субъектүүдэд мэдэгдэлгүйгээр цуглуулж эсвэл олж авах ёсгүй. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Brink's нь Өгөгдлийн субъектүүдэд тэдний Хувийн мэдээллийг боловсруулахтай холбоотой мэдээллийг хялбар олж авч болохуйц, товч, ил тод, ойлгомжтой, энгийн бөгөөд тодорхой бичиж өгөх ёстой, ингэснээр Өгөгдлийн субъектүүд үүнийг хялбархан ойлгох боломжтой болно. Ийм мэдээллийг зохих Нууцлалын мэдэгдлээр өгөх бөгөөд үүнд (боломжтой тохиолдолд) (1) Хувийн мэдээллийг боловсруулж буй Brink's-н аж ахуйн нэгжийн мэдээлэл болон хувийн мэдээлэл боловсруулалт хариуцсан ажилтны мэдээлэл, (2) Хувийн мэдээллийг ашиглаж буй Brink's-ийн зорилго, (3) Өгөгдлийн субъектүүдийн өгөгдөл хамгаалах эрхийн тухай мэдээлэл; (4) холбогдох хууль тогтоомжийн дагуу шударга, ил тод боловсруулалтыг хийхэд шаардлагатай аливаа нэмэлт мэдээлэл багтана.



F.2.

ЗОРИЛГЫН ХЯЗГААРЛАЛТ

Хувийн мэдээллийг нэг эсвэл хэд хэдэн тодорхой, ойлгомжтой, хууль ёсны зорилгоор цуглуулах бөгөөд цуглуулсан анхны зорилгоос өөр байдлаар цаашид ашиглаж болохгүй. Хувийн мэдээллийг анх олж авсан зорилгоос өөр зорилгоор ашиглахыг хориглоно. Анхны зорилгоос өөр зорилгоор ашиглах шаардлага гарсан тохиолдолд өгөгдлийн субъектэд шинэ зорилгын талаар мэдэгдэж зөвшөөрөл авсны үдсэн дээр ашиглаж болно.

F.3.

ӨГӨГДЛИЙН БАГАСГАЛТ

Хувийн мэдээлэл нь Боловсруулж буй зорилгын хувьд шаардлага хангасан, зохимжтой, хамааралтай байх ёстой.

Brink's-н бие бүрэлдэхүүн зөвхөн ажил үүргээ гүйцэтгэхдээ Хувийн мэдээллийг боловсруулж болох бөгөөд цуглуулсан Хувийн мэдээлэл нь хэмжээ болон төрлийн хувьд зориулалтын дагуу шаардлагад тохирсон байх ёстой.

F.4.


ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ

Хувийн мэдээллийг боловсруулж буй хууль ёсны зорилгыг биелүүлэхийн тулд аль болох үнэн зөв бүртгэж, шаардлагатай бол шинэчилж байх ёстой.

F.5.

ХАДГАЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ

Хувийн мэдээллийг анх цуглуулсан зорилгоор эсвэл холбогдох хууль тогтоомжтой уялдуулан цаашид Боловсруулах зорилгоор, тодорхойлж болохуйц хэлбэрээр шаардлагатай хугацаанаас илүү удаан хугацаанд хадгалах ёсгүй.



F.6.

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ НЬ

Хувийн мэдээллийг Хувийн мэдээллийн зөрчлөөс хамгаалах зориулалттай зохих техникийн болон зохион байгуулалтын хамгаалалтаар хамгаална.

Brink's нь өөрийн хэмжээ, хамрах хүрээ, бизнес, боломжит нөөц, өөрийн нэрийн өмнөөс эсвэл бусдын нэрийн өмнөөс Боловсруулж буй Хувийн мэдээллийн нууцлал, систем болон өгөгдөлд учирч болзошгүй эрсдлүүдэд тохирсон хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

Үүнд шаардлагатай бол шифрлэлт болон нууц нэрийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр ашиглаж болно. Brink's-н Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан баг нь Хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд эдгээр хамгаалалтын үр ашигтай байдлыг тогтмол үнэлж, шалгадаг. Brink's-н бие бүрэлдэхүүн Brink's-н эзэмшилд байгаа Хувийн мэдээллийг хамгаалах үүрэгтэй бөгөөд мэдээлэл хамгаалах шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс Brink's нь зөвхөн ажил үүргээ гүйцэтгэх зорилгоор хувийн мэдээллийг авах эрхийг олгодог. Brink's-н ажилчид Brink's-н эзэмшиж буй хувийн мэдээллийг бусад ажилчид, охин компаниуд, болон Brink's-н төлөөлөгчдөд дамжуулахдаа (1) зөвхөн ажил хэргийн шаардлагад үндэслэн дамжуулна, (2) энэхүү журамд заасан шаардлагуудад нийцүүлсэн байна.

Хувийн мэдээллийг үйлчилгээ үзүүлэгч гэх мэт гуравдагч этгээдэд дараах тохиолдолд дамжуулж болно:

- гэрээт үйлчилгээ үзүүлэх зорилгоор хувийн мэдээллийг авах шаардлагатай бол;
- хувийн мэдээллийг хуваалцах нь энэхүү Бодлого болон Өгөгдлийн субъектэд өгсөн Нууцлалын мэдэгдэлд нийцэж байгаа бол, хэрэв холбогдох хуульд заасны дагуу Өгөгдлийн субъект Хувийн мэдээллээ хуваалцахыг зөвшөөрсөн бол;
- гуравдагч этгээд бидний нэрийн өмнөөс Хувийн мэдээллийг зөвхөн Brink's-н тодорхойлсон, зөвшөөрсөн зорилгоор, Brink's-н зааврын дагуу Боловсруулахыг хүлээн зөвшөөрсөн бол; мөн
- гуравдагч этгээд өгөгдлийн аюулгүй байдлын шаардлагатай стандарт, бодлого, журмыг дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрсөн ба аюулгүй байдлын зохих арга хэмжээг авсан тохиолдолд.





F.7.

ДАМЖУУЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ

Brink's олон улсад үйл ажиллагаа явуулдаг тул Хувийн мэдээллийг цуглуулсан улсаас өөр улсын өөр хүн эсвэл байгууллагад Дамжуулж болно.

Хувийн мэдээллийг улс хооронд Дамжуулах тохиолдолд холбогдох хууль тогтоомж болон энэхүү Бодлогын дагуу явагдах ёстой. Шаардлагатай тохиолдолд Brink's холбогдох хуульд заасны дагуу өгөгдөл хамгаалалтын түвшнийг хангуулах зорилгоор шаардлагатай алхамуудыг авна.

F.8.

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ НЬ

Brink's нь Хувийн мэдээллийн зөрчлийг мэдээлэх журмыг хэрэгжүүлсэн бөгөөд хууль ёсны дагуу шаардлагатай бол эсвэл тохиромжтой үед Өгөгдлийн субъектүүд болон/эсвэл холбогдох зохицуулагчдад мэдэгдэх болно.

Хэрэв та Хувийн мэдээлэл зөрчигдсэнийг мэдэж байгаа бол эсвэл сэжиглэж байгаа бол энэ асуудлыг өөрөө шалгах гэж бүү оролд. Мэдээллийн аюулгүй байдлын багтай нэн даруй холбоо барина уу:

ITSecurityTeam@brinksinc.com

Хувийн мэдээллийн зөрчилтэй холбоотой бүх нотлох баримт хадгалагдах ёстой.

F.9.

ӨГӨГДЛИЙН СУБЪЕКТИЙН ЭРХ БА ХҮСЭЛТҮҮД

Өгөгдлийн субъект нь Brink's тэдний хувийн мэдээллийг хэрхэн ашиглахтай холбоотой тодорхой эрх эсвэл сонголттой байж болно.

Үүнд, хэрэв боломжтой бол (1) Хувийн мэдээлэлдээ хандах, (2) Хувийн мэдээллээ засварлах, устгах эсвэл Хувийн мэдээллээ тодорхой зорилгоор ашиглахыг эсэргүүцэх эрхийг (тухайлбал шууд маркетинг) олж авах болон хүсэх эрх багтана.

Brink's Хувийн мэдээллийн хамгаалалтыг хангахын зэрэгцээ холбогдох хуулийн дагуу өгөгдлийн субъектүүдийн эрхийн хүсэлтийг шийдвэрлэх үйл явцтай. Brink's Хувийн мэдээлэлдээ хандах эсвэл Хувийн мэдээлэлдээ арга хэмжээ авах хүсэлт гаргасан хувь хүний таних мэдээллийг баталгаажуулах ёстой. Хүсэлтийг гуравдагч этгээд (Өгөгдлийн субъектээс бусад) гаргасан тохиолдолд Brink's-н бие бүрэлдэхүүн Өгөгдлийн субъектийн нэрийн өмнөөс гуравдагч этгээд үйлдэл хийх эрхтэй эсэхийг баталгаажуулахгүйгээр Хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулах ёсгүй.

Аливаа ажилтан/ажилд орох өргөдөл гаргагчийн Өгөгдлийн субъектийн хүсэлтийг хүлээн авмагц нэн даруй дотоодын хүний нөөцийн төлөөлөгч / Хэлтсийн даргад дамжуулна. Аливаа үйлчлүүлэгчийн Өгөгдлийн субъектийн хүсэлтийг хүлээн авмагц нэн даруй дотоодын Бизнесийн төлөөлөгч / Үйлчлүүлэгчийн тусламжийн төвд дамжуулна.

Хүний нөөц болон Бизнесийн төлөөлөгчид Өгөгдлийн субъектийн аливаа хүсэлт, үүнийг зохицуулахаар авсан арга хэмжээний талаар DPO (эсвэл томилсон албан хаагч)-д нэн даруй мэдэгдэх болно.



G. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЧАДВАР

Brink's-н аж ахуйн нэгж бүр энэхүү Бодлогыг өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүний тулд Brink's-н аж ахуйн нэгжүүд энэхүү Бодлогод тусгагдсан Зарчмуудыг дагаж мөрдөхийн тулд техникийн болон зохион байгуулалтын зохих арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх бөгөөд үүнд Хувийн мэдээллийн хандалтыг хязгаарлах, хянах арга хэмжээ, Brink's-н бие бүрэлдэхүүнийг энэхүү Бодлого, Хэрэгжүүлэх баримт бичиг болон бусад холбогдох нууцлал эсвэл аюулгүй байдлын арга хэмжээнд тогтмол сургах, ямар нэг нөхцөлд практик ач холбогдолтой байж болох ба/эсвэл шаардлагатай өгөгдөл хамгаалах дадлыг бий болгох арга хэмжээ багтана.

Brink's Хувийн мэдээллийг зохистой ашиглах, хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн нууцлалын арга хэмжээг тогтмол шалгаж байх болно.

H. ЖИЛИЙН ТОЙМ

Brink's энэхүү Бодлогыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Brink's-н Олон улсын DPO энэхүү Бодлогыг холбогдох хууль тогтоомжид нийцэж байгааг хянаж, тогтмол үнэлэх болно. Дээр дурдсан зүйлийг үл харгалзан энэхүү Бодлогыг зохих ёсоор Brink's-н Олон улсын DPO-с жилд дор хаяж нэг удаа албан ёсоор хянаж, шинэчилж байх болно. Бодлогод зохицуулалтын эсвэл бусад шаардлагын улмаас өөрчлөлт оруулах хэрэгтэй тохиолдолд ийм өөрчлөлтийг тусгахын тулд Бодлогод нэн даруй нэмэлт өөрчлөлт оруулна.

Нөөц болон холбоо барих хаягийн мэдээллийг авахын тулд Олон улсын хууль эрх зүйн сүлжээ болон түүний Өгөгдөл хамгаалах хэсэгт зочилно уу.

<https://customerportal.brinksinc.com/en/web/brinks-resource-library/global-legal>

